

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/001/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.17 № 406
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЦАСЧИХЭР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Чадамжийн эрин ТББ-тай нийт 12 удаагийн сургалт зохион байгуулахаар 2.0 сая төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 2.3-д "... сургалт дууссанаас хойш 7 хоногийн дотор сургалт зохион байгуулсан тайлан, үр дүнг хүргүүлнэ" гэснийг хэрэгжүүлээгүй, гэрээнд заагдсан хугацаанд сургалтыг дуусгаагүй байна. Байгаль орчин нийгэм эдийн засгийн судалгаа хөгжлийн амжилтын зөвлөх төв ТББ-тай 4 удаагийн сургалт зохион байгуулахаар 1.2 сая төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 1.3-д "...захиалагч талаас шаардсан мэдээллийг агуулсан ажил, үйлчилгээний тайланг хүлээлгэн өгнө" гэсэн шаардлага хангахгүй тайлан өгсөн байна. Нийт 3.2 сая төгрөгийн гэрээг дүгнээгүй, үр дүнг тодорхой оновчтой тайлагнаагүй, Эрх бүхий байгууллагаас баталсан доод хязгаараас бага дүнгээр түрээсийн төлбөрийг тооцон, орлогыг 6.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг

011022195

хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтыг мөрдөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

“Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын тамгын газраас 85.1 хувьтай үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх ~~үндэслэлтэй байвал материаллаг~~ гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,477,326.60</u>	<u>38,968,218.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,876.60	26,168.67
312	Банканд байгаа бэлэн мөнгө	28,876.60	26,168.67
31213	Арилжааны банк дахь харилцах	28,876.60	26,168.67
35	БАРАА МАТЕРИАЛ	14,448,450.00	38,942,050.00
354	Хангамжийн материал	14,448,450.00	38,942,050.00
35410	Бичиг хэргийн материал	1,417,900.00	1,913,000.00
35420	Аж ахуйн материал	1,692,600.00	1,678,600.00
35470	Бусад хангамжийн материал	11,337,950.00	35,350,450.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>690,359,446.45</u>	<u>692,627,050.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	690,359,446.45	692,627,050.66
392	Биет хөрөнгө	679,421,946.53	687,064,550.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	800,936,638.12	800,936,638.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(187,706,044.82)	(259,388,711.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,054,900.00	20,054,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,392,402.25)	(11,988,127.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,070,000.00	18,070,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,478,894.36)	(8,084,927.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,685,000.00	44,470,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(747,250.16)	(5,788,521.07)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	88,783,300.00
393	Биет бус хөрөнгө	10,937,499.92	5,562,499.88
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(562,500.00)	(937,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,000,000.08)	(15,000,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>704,836,773.05</u>	<u>731,595,269.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>467,344.28</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	467,344.28
413	Өглөг	-	467,344.28
4136	Бусад өглөг	-	467,344.28
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	467,344.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>704,836,773.05</u>	<u>731,127,925.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	704,836,773.05	731,127,925.05
512	Хуримтлагдсан үр дүн	704,836,773.05	731,127,925.05
51210	Өмнөх үеийн үр дүн	57,569,944.09	704,836,773.05
51220	Тайлант үеийн үр дүн	647,266,828.96	26,291,152.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>704,836,773.05</u>	<u>731,595,269.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	927,928,630.98	418,058,661.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	927,928,630.98	418,058,661.74
120	Нийтлэг татварын бус орлого	909,928,630.98	418,058,661.74
120002	Хүүгийн орлого	332,037.68	64,411.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	260,366,000.00	305,770,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	197,926,000.00	236,250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,440,000.00	69,520,950.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	649,230,593.30	88,783,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	23,440,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	18,000,000.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	18,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	274,675,002.92	391,767,509.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,675,002.92	391,767,509.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,413,766.94	331,764,360.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,181,201.00	159,028,491.00
210101	Үндсэн цалин	100,181,201.00	159,028,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,156,806.00	21,832,081.00
210201	Тэтгэврийн даатгал	11,053,952.00	15,423,751.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,300,463.00	1,796,558.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,970.00	1,257,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,493.00	304,902.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,534,928.00	3,049,035.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,374,745.00	33,854,814.00
210301	Гэрэл, цахилгаан	23,152,431.00	27,234,102.00
210303	Цэвэр, бохир ус	5,222,314.00	6,620,712.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,349,316.67	13,654,450.00
210401	Бичиг хэрэг	1,412,900.00	1,947,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,762,000.00	998,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,213.02	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,300.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,426,903.65	7,401,650.00
210408	Бараа материал акталсны зардал	-	127,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,600,000.00
210604	Урсгал засвар	-	1,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,070,000.00	852,000.00
210702	Дотоод албан томилолт	11,070,000.00	852,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,150,152.66	5,920,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,355,952.66	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	4,225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00

Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	74,200.00	55,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,131,545.61	94,643,824.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,473,203.77	5,343,128.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,658,341.84	89,300,695.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,235.98	60,381,149.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	261,235.98	60,381,149.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	261,235.98	60,381,149.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>653,253,628.06</u>	<u>26,291,152.00</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,986,799.10	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,986,799.10	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,986,799.10)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>647,266,828.96</u>	<u>26,291,152.00</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>278,698,037.68</u>	<u>305,835,361.74</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,698,037.68	305,835,361.74
120	Нийтлэг татварын бус орлого	260,698,037.68	305,835,361.74
120002	Хүүгийн орлого	332,037.68	64,411.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	260,366,000.00	305,770,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	197,926,000.00	236,250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,440,000.00	69,520,950.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	18,000,000.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	18,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>278,689,161.08</u>	<u>305,838,069.67</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,689,161.08	305,838,069.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,427,925.10	245,456,920.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,181,201.00	159,028,491.00
210101	Үндсэн цалин	100,181,201.00	159,028,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,156,806.00	21,832,081.00
210201	Тэтгэврийн даатгал	11,053,952.00	15,423,751.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,300,463.00	1,796,558.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,970.00	1,257,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,493.00	304,902.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,534,928.00	3,049,035.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,374,745.00	33,854,814.00
210301	Гэрэл, цахилгаан	23,152,431.00	27,234,102.00
210303	Цэвэр, бохир ус	5,222,314.00	6,620,712.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,223,166.67	11,188,050.00
210401	Бичиг хэрэг	1,990,900.00	2,442,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,682,000.00	998,000.00

Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,213.02	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,300.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,802,753.65	4,567,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,467,050.00	5,540,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,850,000.00	-
210602	Тавилга	940,000.00	-
210604	Урсгал засвар	11,677,050.00	5,540,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,070,000.00	852,000.00
210702	Дотоод албан томилолт	11,070,000.00	852,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,150,152.66	5,920,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,355,952.66	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	4,225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	74,200.00	55,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,804,803.77	7,240,784.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,804,803.77	7,240,784.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,235.98	60,381,149.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	261,235.98	60,381,149.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	261,235.98	60,381,149.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,876.60</u>	<u>(2,707.93)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,876.60	(2,707.93)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	28,876.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,876.60	26,168.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	704,836,773.05	704,836,773.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	704,836,773.05	704,836,773.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
Тайлант үеийн үр дүн	0.00	26,291,152.00	26,291,152.00
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	731,127,925.05	731,127,925.05

2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	хувь
НИЙТ ОРЛОГО				
I. ОРЛОГЫН ДҮН	226,250,000.00	245,770,950.00	(19,520,950.00)	108.63
Үндсэн үйл ажиллагааны орлого	176,250,000.00	176,250,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлого	50,000,000.00	69,520,950.00	(19,520,950.00)	139.04
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	226,250,000.00	226,154,743.00	95,257.00	99.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	226,250,000.00	226,154,743.00	95,257.00	99.96
Үндсэн цалин	159,031,000.00	159,028,491.00	2,509.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	21,847,000.00	21,832,081.00	14,919.00	99.93
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,102,800.00	28,070,671.00	32,129.00	99.89
Гэрэл, цахилгаан	6,599,700.00	8,177,145.00	(1,577,445.00)	123.90
Түлш, халаалт	16,703,100.00	15,072,344.00	1,630,756.00	90.24
Цэвэр, бохир ус	4,800,000.00	4,821,182.00	(21,182.00)	100.44
Хангамж бараа материалын зардал	7,604,200.00	7,604,200.00	-	100.00
Бичиг хэрэг	2,442,900.00	2,442,900.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00	-	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,981,300.00	1,981,300.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,500,000.00	-	100.00
Урсгал засвар	5,500,000.00	5,500,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,765,000.00	1,719,300.00	45,700.00	97.41
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж			-	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,225,000.00	1,225,000.00	-	100.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00	-	100.00
Татвар				
Банк хураамж	100,000.00	54,300.00	45,700.00	54.30
Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.4 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Хөрөнгийг шууд зарлагдсаныг буцаан орлого болгож залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10.0 сая төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд албан шаардлага өгсөн.

1. Чадамжийн эрин ТББ-тай нийт 12 удаагийн сургалт зохион байгуулахаар 2.0 сая төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 2.3-д "... сургалт дууссанаас хойш 7 хоногийн дотор сургалт зохион байгуулсан тайлан, үр дүнг хүргүүлнэ" гэснийг хэрэгжүүлээгүй, гэрээнд заагдсан хугацаанд сургалтыг дуусгаагүй байна. Байгаль орчин нийгэм эдийн засгийн судалгаа хөгжлийн амжилтын зөвлөх төв ТББ-тай 4 удаагийн сургалт зохион байгуулахаар 1.2 сая төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 1.3-д "...захиалагч талаас шаардсан мэдээллийг агуулсан ажил, үйлчилгээний тайланг хүлээлгэн өгнө" гэсэн шаардлага хангахгүй тайлан өгсөн байна. Нийт 3.2 сая төгрөгийн гэрээг дүгнээгүй, үр дүнг тодорхой оновчтой тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Эрх бүхий байгууллагаас баталсан доод хязгаараас бага дүнгээр түрээсийн төлбөрийг тооцон, орлогыг 6.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолын хавсралтыг мөрдөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийг шууд зарлагдсаныг буцаан орлого болгож залруулав.	1	378.0	-	-	1	378.0	1	378.0	-	-	--	-
Дүн	1	378.0	-	-	1	378.0	1	378.0	-	-	-	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Гэрээний заалтын мөрдөлтөд хяналт тавиагүй, үр дүнг дүгнээгүй	1	3,200.0	-	-	1	3,200.0	-	-	-	-	-	-
Эрх бүхий байгууллагаас баталсан доод хязгаараас бага дүнгээр түрээсийн төлбөрийг тооцон, орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	6,764.1	-	-	1	6,764.1	-	-	-	-	-	-
Дүн	2	9,964.1	-	-	2	9,964.1	-	-	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 01/95/19125199

Чойбалсан хот

2024-0025/001/НА-СТА-ОНӨУГ

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагаас баталсан доод хязгаараас бага дүнгээр түрээсийн төлбөрийг тооцон авч, орлогыг 6,764,074.01 төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтыг мөрдөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж, түрээсийг төлбөрийг баталж гэрээ байгуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цасчихэр, нягтлан бодогч С.Мөнхтуяа нарт даалгав.

2125040572

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР




И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 02/96/49125099

Чойбалсан хот

20А-2025/001/НАСТА-ОНӨНГ

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чадамжийн эрин ТББ-тай нийт 12 удаагийн сургалт зохион байгуулахаар 2,000,000.00 төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 2.3-д "... сургалт дууссанаас хойш 7 хоногийн дотор сургалт зохион байгуулсан тайлан, үр дүнг хүргүүлнэ" гэснийг хэрэгжүүлээгүй, гэрээнд заагдсан хугацаанд сургалтыг дуусгаагүй байна. Байгаль орчин нийгэм эдийн засгийн судалгаа хөгжлийн амжилтын зөвлөх төв ТББ-тай 4 удаагийн сургалт зохион байгуулахаар 1,200,000.00 төгрөгийн сургалтын гэрээ хийсэн байна. Гэрээний 1.3-д "...захиалагч талаас шаардсан мэдээллийг агуулсан ажил, үйлчилгээний тайланг хүлээлгэн өгнө" гэсэн шаардлага хангахгүй тайлан өгсөн байна. Нийт 3,200,000.00 төгрөгийн гэрээг дүгнээгүй, үр дүнг тодорхой оновчтой тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан, тооллого тооцооны бүх баримтыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, эмхлэн цэгцэлж, бүрэн гүйцэт бүрдэлтэйгээр архивд актаар шилжүүлэх", 4.2.1-т "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт

2125040575

зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавих, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨААТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цасчихэр, нягтлан бодогч С.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ